

Төв аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны дугаар сарын-ний өдрийн дугаар албан бичгийн хавсралт

ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2024.06.05.

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин /эхний хагас жил/ | Хүрсэн түвшин, хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|------------------------|--|--------------|-----------------------------------|---|-------------------|
| БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАСАН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |
| Гүйцэтгэлийн зорилт 1.1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Залуучуудын манлайлал-Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил” урианы жилийн ажлын хүрээнд | | | | | | | |
| 1.1.1. | Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч, иргэдийг сайн дурын даатгалд хамруулах зорилгоор сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тоог 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ. | 5150 иргэн | 2800 иргэн | Нийгмийн даатгалын газар нь иргэд даатгуулагчдын нийгмийн даатгалын ач холбогдлын талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах сургалт, нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулж байна. Тухайлбал, 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Монгол туургатан театрт 300 гаруй иргэд, даатгуулагчдад, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газартай хамтран 160 гаруй албан хаагчдыг хамарсан сургалтыг 05 дугаар сарын 15-ны өдөр, аймгийн Эрүүл мэндийн газрын 30 гаруй албан | 100 |

| | | | | | | |
|--|--|--|--|--|---|--|
| | | | | | <p>хаагчдад 05 дугаар сарын 27-ны өдөр тус тус зохион байгууллаа. Нийгмийн даатгалын багц хууль, нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Архуст, Мөнгөнморьт, Эрдэнэ суманд 2024 оны 05 дугаар сарын 13-18-ны өдөр, Алтанбулаг суманд 06 дугаар сарын 05-ны өдөр, Баяндэлгэр суманд 06 дугаар сарын 06-ны өдөр, Зуунмод сумын багийн иргэдийн нийтийн ээлжит 10 удаагийн хуралд, аж ахуйн нэгж байгууллагуудад захиалгат сургалт мэдээлэл хийх зэрэг үйл ажиллагааг тус тус зохион байгууллаа. Түүнчлэн аймгийн “Төв телевиз”тэй хамтран ажиллах гэрээ байгуулж ТВ шууд нэвтрүүлэг, цахим мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээж, сурталчилж байна. Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга, үйлчилгээний талаар нийт 8 төрлийн гарын авлага боловсруулан хэвлэж сургалт, сурталчилгаанд ашиглаж байна. Дээрх арга хэмжээг үе шаттай зохион</p> | |
|--|--|--|--|--|---|--|

| | | | | | | | |
|-------|--|------------------------|-----------------------------------|----|---|---|-----|
| | | | | | | байгуулсны үр дүнд нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчдын тоо 2024 оны эхний хагас жилийн байдлаар 4044 хүрсэн байна. Нийт сайн дураар даатгуулагчдын 859 буюу 21 хувийг 35 хүртэлх насны залуучууд эзэлж байна. | |
| 1.1.2 | Залуучуудын манлайлал-Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн ажлын хүрээнд байгууллагын албан хаагчдын ажиллах, амрах, ая тухтай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн тохижилтын ажил хийнэ. | Үйл ажиллагааны зардал | Өрөө тасалгааг тохижуулсан байна. | - | Нийт албан хаагчдад ажиллах ая тухтай орчин бий болсон байна. | Мөн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх, олон нийтэд таниулах, сурталчлах "Ногоон-Сэргэлт, Ногоон-Төв аймаг" бүх нийтээр мод тарих сарын аяны хүрээнд "Баатаруудын цэцэрлэгт хүрээлэн"-нд 10 ширхэг тэхийн шээгний мод тарьсан. Мөн Нийгмийн даатгалын газар нь гадны талын талбайн хагархайг болон ЭМДХ-ийн үүдний шатыг цементээр бөглөж, газрын дотоод тохижилтийг сайжруулж цэцгүүдийн ваарыг шинэчилж, мандлын цэцэг тарьсан. Байгууллагын барилгын гаднах хаягийг крилл болон монгол бичгээр шинэчлэн хийлгэсэн. Мөн газрын албан хаагчдад зориулан ширээний теннис дартс тоглох нөхцөлийг бүрдүүлээд байна. | 100 |
| 1.1.3 | Өв соёлоо эрхэмлэж үндэсний бичгээ сурцгаая- аян | Үйл ажиллагааны зардал | 1.Нийт албан хаагчдын 10- | 16 | 2 албан хаагчийг анхан болон | "Өв соёлоо эрхэмлэж үндэсний бичгээ сурцгаая-2025" аян өрнүүлэн, төрийн | 100 |

| | | | | | |
|---|--|---|--|---|------------|
| <p>өрнүүлэн, төрийн хаагчдын хэл, чадварыг дээшлүүлж, албан хөтлөлтийг бичгээр ажлыг туршина.</p> <p>"2025 албан монгол бичгийн төрийн хэрэг хос хөтлөх</p> | <p>аас доошгүй хувийг монгол бичгийн сургалтад хамруулна.</p> <p>2. Монгол бичгээр албан хэрэг хөтлөх программ ашиглах сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо</p> <p>3.Хос бичгээр туршсан албан бичгийн тоо</p> <p>4.Гадна болон өрөө тасалгааны хаяг, хавтсыг зэрэгцүүлэн бичсэн байдал</p> | <p>дунд шатны мэдлэг эзэмшүүлнэ</p> | <p>албан хаагчдын монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлж, төрийн албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөх ажлыг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын зайн ДИНАМИК системээр 42 байцаагч Монгол бичгээр бичих ур чадварын сургалтад 7 хоног тутамд нэг удаа хамрагдан бичих ур чадвараа дээшлүүлэн суралцаж байна.</p> | | |
| | | <p>2 албан хаагч</p> | <p>5 албан хаагч</p> | <p>Газрын Бичиг хэрэг, хүний нөөц, дотоод асуудал хариуцсан болон архив, хөрөнгө хариуцсан 2 албан хаагчийг монгол бичгээр албан хэрэг хөтлөх программ ашиглах сургалтад хамруулсан.</p> | <p>100</p> |
| | | <p>10 албан бичиг гарган туршсан байна.</p> | <p>5-оос доошгүй албан бичиг гарган туршсан байна.</p> | <p>Хос бичгээр албан бичиг турших ажлын хүрээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 5 албан бичигт туршилт хийгээд байна.</p> | <p>90</p> |
| | | <p>-</p> | <p>Кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн хаягжүүлсэн байна.</p> | <p>Газрын байрны гадаа болон дотоод хаяг, гэрчилгээ, батламж, хавтасны хаяг, нэрийн хуудас, салбарын болон аймгийн урианы жилийг монгол кириллээр зэрэгцүүлэн хөтлөн ажиллаж байна. "Монгол бичгээр</p> | <p>100</p> |

| | | | | | | | |
|-------|---|-------------------------------|---|---|----------------|--|-----|
| | | | | | | <p>үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS 6395:2022, "Төрийн албан хаагчийн нэрийн хуудсанд тавих ерөнхий шаардлага" MNS 6978:2022, "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага" MNS 5283:2022, "Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо. Тооцоолох хэрэгслийн гарын товчлуур дээрх монгол бичгийн үсэг, тэмдгийн байршил" MNS 7004:2023 стандартуудыг албан ажлын хэрэгцээнд худалдан авч, өдөр тутмын хэрэглээнд ашиглаж байна.</p> | |
| 1.1.4 | <p>Өв соёлоо эрхэмлэж үндэсний бичгээ сурцгаая- аян өрнүүлэн, "2025 төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлж, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.</p> | <p>Үйл ажиллагааны зардал</p> | <p>Албан хаагчид монгол бичгийн сургалтад хамрагдсан байна.</p> | - | 54 албан хаагч | <p>Өв соёлоо эрхэмлэж үндэсний бичгээ сурцгаая- аян өрнүүлэн, "2025 төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлж, нийт төрийн албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг улирал бүр дүгнэн ажиллаж байна.</p> | 100 |

| | | | | | | | |
|---|--|------------------------|---|--|--|---|-----|
| 1.1.5 | Шинэ сэргэлтийн бодлого, төрийн бүтээмж дээшлүүлэх зорилт арга хэмжээний хүрээнд тоон гарын үсэг олгох, тоон гарын үсгээр тайлан хүлээн авах ажлыг эрчимжүүлэн ажиллана. | Үйл ажиллагааны зардал | Шимтгэл төлөгч буюу ажил олгогч нар тоон гарын үсэг олгон төрийн үйлчилгээнд түргэн, шуурхай хамрагдах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах. | Шинээр олгосон тоон гарын үсэг: 59 Тайлан илгээлт: 59 | Шинээр тоон гарын үсгээр тайлан илгээх ААН-ийн тоог 30-д хүргэнэ | Шинээр 15 ажил олгогчид тоон гарын үсэг олгон төрийн үйлчилгээнд түргэн, шуурхай хамрагдах нөхцөлийг бүрдүүлэв. | 100 |
| Гуйцэтгэлийн зорилт № 1.2. Нийгмийн даатгалын хууль тогтоомж болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд | | | | | | | |
| 1.2.1 | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг биелүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Батлагдсан сангийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар өссөнөөр жигд биелүүлэн ажилласан байна. | 42051.5 сая төгрөг | 25197.6 сая төгрөг | Нийгмийн даатгалын газар 2024 оны эхний хагас жилийн байдлаар 25.4 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого бүрдүүлэн орлогын төлөвлөгөөг 100.9 хувиар давуулан биелүүлсэн бөгөөд төвлөрсөн сангийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт төвлөрүүлж ажилласан. | 100 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, авлагыг барагдуулах арга хэмжээ зохион байгуулж, оны эхний үлдэгдлээс бууруулна. | Үйл ажиллагааны зардал | Шимтгэлийн өглөг авлагын оны эхний үлдэгдлийг 30-аас доошгүй хувиар бууруулах, | 40 %-иар бууруулсан | Шимтгэлийн авлага: 3344.8 сая төгрөгийг 2675.9 сая төгрөг болгон | 2024 онд нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагыг оны эхний үлдэгдлээс 30 хувиар бууруулах зорилт тавьсан. Эхний хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлагыг | 100 |

| | | | | | | | |
|-------|---|------------------------|---|--|--------------------|---|-----|
| | | | нэмж үүсгэхгүй байх арга хэмжээ авч ажилласан байна. Оны эхний үлдэгдлээс 30-аас доошгүй хувиар бууруулах | | бууруулсан байна. | 3071.2 сая төгрөгт хүргэж оны эхнээс 273.6 сая төгрөгөөр буюу 20 хувиар бууруулав. | |
| 1.2.3 | Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг батлагдсан төсвийн дагуу зарцуулна | Үйл ажиллагааны зардал | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчд ад тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээг үзүүлсэн байна | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, бусад зардалд 159753.2 сая төгрөг зарцуулсан | 78258.5 сая төгрөг | Нийгмийн даатгалын газар 2024 оны эхний хагас жилийн байдлаар 25.4 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого бүрдүүлэн орлогын төлөвлөгөөг 100.9 хувиар давуулан биелүүлсэн бөгөөд төвлөрсөн сангийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт төвлөрүүлж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжид 76.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Мөн эхний хагас жилийн байдлаар 1037.5 сая төгрөг батлагдсанаас 991.1 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг 46.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна. | 100 |
| 1.2.4 | Батлагдсан төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, | Үйл ажиллагааны зардал | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн | 1595.0 сая төгрөг | 994.6 сая төгрөг | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд сургалт, сурталчилгаа, хурал, зөвлөгөөнийг тухай бүрт | 100 |

| | | | | | | | |
|-------|---|------------------------|---|--|----------------------------------|---|-----|
| | хэмнэлтийн зарчмыг баримтална. | | ангилал хооронд шилжүүлэн зарцуулагүй байна. Ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажилласан байна | | | цахим хэлбэрээр зохион байгуулж байна. Түүнчлэн Төв ТВ-тэй байгуулсан гэрээний дагуу нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын үйлчилгээний талаар цуврал ярилцлага нэвтрүүлэг, Төв ТВ цахим хуудас болон Нийгмийн даатгалын газрын цахим хуудсаар дамжуулан мэдээ, мэдээллийг тогтмол түгээж ажиллаж байна. | |
| 1.2.5 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, санхүүгийн сар, улирал, хагас, бүтэн жилийн мэдээ, тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлж ажиллана. | Үйл ажиллагааны зардал | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна. | Мэдээ тайлан цаглабрын дагуу гарсан байх | 6 тайлан, мэдээ | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалын сангийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтлөх журмын дагуу нийгмийн даатгалын сангуудын болон байгууллагын санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг 6 удаа гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газарт хугацаанд нь хүргүүлэв. | 100 |
| 1.2.6 | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч | Үйл ажиллагааны зардал | Шинээр худалдан авах, шилжүүлэх, | 2023 онд 601.3 сая төгрөгийн хөрөнгөнд | Цаглабрын дагуу холбогдох мэдээ, | Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу ажилчдын цалин хөлсийг батлагдсан төсвийн хүрээнд | 100 |

| | | | | | | | |
|--|--|--|--|---|--|--|--|
| | <p>хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт, хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнана.</p> | | <p>актлах, устгах болон нийгмийн даатгалын сангийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой саналыг НДҮЗ, ТӨБЗГ-т санал дэвшүүлж шийдвэрлүүлэх; НД-ын байгууллагын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн (байгууллагын эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө гэх мэт) нэгдсэн судалгааны хөдөлгөөн, өөрчлөлтөд байнга хяналт тавьж,</p> | <p>бүртгэлээр хяналт тавьж ажилласан.</p> | <p>тайланг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна.</p> | <p>шимтгэлийн болон татварын өр авлага үүсгэхгүй ажиллаж байна. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Төсвийн хуваарь батлах тухай” А/03 дугаар тушаалаар 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын жилийн төсөвт 1890086,1 мянган төгрөг батлагдсан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 1037580,2 мянган төгрөгийн санхүүжилт орж ирснээс төсвийн хуваарийн дагуу зарцуулсан. “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ын хүрээнд 2024 оны хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын газрын 47 албан хаагчид 87.6 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдэл олгоод байна. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу орон нутагт</p> | |
|--|--|--|--|---|--|--|--|

| | | | | | | | |
|-------|---|------------------------|---|---|---|--|-----|
| | | | тайлан мэдээг тухай бүр гарган тайлагнана. | | | төрийн захиргааны албан тушаалд томилогдон тасралтгүй 5 жил ба түүнээс дээш хугацаагаар ажилласан тус газрын төрийн захиргааны 22 албан хаагчид 137.2 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгов. | |
| 1.2.7 | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, жилийн эцсийн тайланд аудит хийлгэнэ. | Үйл ажиллагааны зардал | Зөрчилгүй дүгнэлт авч, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна | Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг 100 хувь биелүүлэх. | Зөрчилгүй дүгнэлт авч ажилласан байна. | 2023 оны нийгмийн даатгалын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймгийн Төрийн аудитын газарт хугацаанд нь хүргүүлэн шалгуулж зөрчилгүй дүгнэгдсэн. | 100 |
| 1.2.8 | Нийгмийн даатгалын газрын 2025 оны төсвийн төсөл, төсөөллийн саналыг боловсруулж, саналыг НДЕГ-т хуулийн хугацаанд хүргүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Төсвийн төслийг хуулийн хугацаанд НДЕГ-т хүргүүлсэн байх | Хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан байна. | Төсвийн төслийг хуулийн хугацаанд НДЕГ-т хүргүүлж, "Шилэн данс"-д байршуулна. | 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төслийг саналыг боловсруулж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт судалгааны газарт хугацаанд нь хүргүүлэв. | 100 |
| 1.2.9 | Тэтгэврийн даатгалын сан, тэтгэмжийн даатгалын сан, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах иргэдийн хүсэлтийг хүлээн авч | Үйл ажиллагааны зардал | Үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо, үйлчилгээний төрөл тус бүрээр | Ажилгүйдлийн тэтгэмж: 498 даатгуулагчид 1309.5 сая төгрөг ХЧТА: 1363 даатгуулагчид 278.1 сая төгрөг | Ажилгүйдэл: 250 иргэнд 777.1 сая ХЧТА: 650 иргэн 230.4 сая ЖА: 600 эхэд 1592.2 сая төгрөг | Тэтгэмжийн даатгалын сангаас 2024 оны эхний хагас жилийн байдлаар ажилгүйдлийн тэтгэмжийг 410 иргэнд 792.7 сая төгрөг, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 372 иргэнд 117.7 сая төгрөг, Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 520 иргэнд 2019.6 сая төгрөгийг | 100 |

| | | | | | | | |
|--------|---|------------------------|----------------------------|---|------------------------------|--|-----|
| | хуулийн хугацаанд нь шийдвэрлэнэ. | | | ЖА: 1205 даатгуулагч ид 2539.8 сая төгрөг | | тус тус хуулийн хугацаанд олгож шийдвэрлэв. | |
| 1.2.10 | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сайн дураар даатгуулагч 0-3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн төлбөл зохих шимтгэлийн тодорхой хувийг төрөөс болон зохих сангаас төлүүлэх арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавьж ажиллана. | Үйл ажиллагааны зардал | Даатгуулагч эхийн тоо | 751 эхийг хамруулж, 267.3 сая төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн. | 30 эхийг шинээр хамруулна. | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 0-3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа 760 эхийг нийгмийн даатгалд сайн дурын даатгалд хамруулж, 165.6 сая төгрөгийн шимтгэлийн төлбөрийг тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс төлүүлж хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэв. | 100 |
| 1.2.11 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажилгүй байгаа эцэг, эхчүүдийн төлбөл зохих шимтгэлийн тодорхой хувийг төрөөс болон зохих сангаас төлүүлэх арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавьж ажиллана. | Үйл ажиллагааны зардал | Хамрагдсан эцэг, эхийн тоо | - | 100 эцэг, эхийг хамруулна | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажилгүй байгаа 28 эцэг, эхчүүдийн төлбөл зохих 12.7 сая төгрөгийн шимтгэлийн гулсын төсвөөс төлүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллав. | 100 |
| 1.2.12 | Малчдын төлбөл зохих шимтгэлийн тодорхой хувийг төрөөс төлүүлэх арга хэмжээг зохион | Үйл ажиллагааны зардал | Малчдын тоо | 1661 | Шинээр 100 малчныг хамруулна | Малчдын төлбөл зохих шимтгэлийн тодорхой хувийг төрөөс төлүүлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд 645 малчныг | |

| | | | | | | | |
|--------|--|------------------------|-----------------------------------|---|---|---|-----|
| | байгуулж, хяналт тавьж ажиллана. | | | | | хамруулж 97.9 сая төгрөгийг улсын төсвөөс төлүүлэв. | |
| 1.2.13 | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийнэ. | Үйл ажиллагааны зардал | Хяналт шалгалт хийгдсэн сумын тоо | - | Архуст, Баяндэлгэр, Баянжаргалан, Мөнгөнморьт, Эрдэнэ | Архуст, Мөнгөнморьт, Эрдэнэ сумдад хяналт шалгалт хийж 26 ажил олгогчийг шалгалтад хамруулж Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчсөн зөрчлийг илрүүлэн 8 ажил олгогчид 3.6 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, актын төлбөрийг бүрэн барагдуулав. 2022, 2023 онд шинээр тогтоогдсон 175 тэтгэвэр авагчийн тогтоолт, олголтод хяналт шалгалт хийж 19 тэтгэврийн хувийн хэрэгт зөрчил илрүүлнээс 5 тэтгэврийг зогсоож, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг буруу тооцож тогтоосон 5 тэтгэвэр авагчид 9.1 сая төгрөг илүү олгосныг төлүүлэх, 8 тэтгэвэр авагчид 1.8 сая төгрөг дутуу олгосныг нөхөн олгохоор улсын байцаагчийн акт тогтоов. 2022, 2023 онд нас барсан 62 тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтыг шалгахад Архуст сумын Х.Лхагвадоржийн 2022 оны 5 сарын тэтгэврийг файл болон жагсаалтаар давхардуулан олгож 500,000 төгрөг илүү олгосныг санд | 100 |

| | | | | | | | |
|--------|---|------------------------|---|-----------------|-----|---|-----|
| | | | | | | буцаан төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож шийдвэрлэв. Шалгалтын хугацаанд 27 ажил олгогчийн 118.5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрөөс 8 ажил олгогчийн 25.4 сая төгрөгийн өрийг барагдуулж, 5 ажил олгогчид өр авлага барагдуулах хугацаатай албан шаардлага өгч ажиллалаа. НДСангийн бусад өглөг, авлага шалгах ажлын хүрээнд 27.5 сая төгрөг өглөг, 22.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тулгахад 4.8 сая төгрөгийн авлага хаах байтал өглөгөөр бүртгэснийг нягтлан бодох бүртгэлийн залруулга бичилт хийж зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллав. | |
| 1.2.14 | Ажил олгогч, иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын лавлагаа, мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр гаргах үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай үзүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Архивын лавлагаа авсан даатгуулагчийн тоо | 819 даатгуулагч | 250 | Нийгмийн даатгалын үйлчилгээ И-монголия цахим системд нэвтэрсэнтэй холбоотой цаасан лавлагаа авах үйлчилгээ авах иргэд, даатгуулагчдын ачаалал өмнөх онуудаас харьцангуй буурч байна. Тус газар 2024 оны эхний хагас жилийн байдлаар 291 даатгуулагчид шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолт гаргах үйлчилгээ үзүүлсэн байна. | 100 |

ХОЁР.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИИГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Гүйцэтгэлийн зорилт 2. Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон нийт, харилцагч аж ахуйн нэгж, байгууллагад мэдээлэл түгээх, хамтран ажиллах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” ажлын хүрээнд

| | | | | | | | |
|------|---|------------------------|--------------------------------------|--|--|---|-----|
| 2.1. | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим систем”-ийн баяжилтыг тухай бүр шинэчилнэ. | Үйл ажиллагааны зардал | Баяжилт хийгдсэн байцаагчийн тоогоор | 37 ажилтны мэдээлэлд баяжилт хийгдсэн. | Баяжилт хийгдсэн төрийн албан хаагчийн тоогоор | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим систем”-ийн баяжилтыг хүний нөөцийн ажилтан тогтмол хийж байна. Тухайлбал, шинээр томилогдсон болон ажил хавсран гүйцэтгэгчээр томилогдсон 3, өөр ажилд шилжсэн болон ажлаас чөлөөлөгдсөн 1 албан хаагчийн мэдээллийн баяжилтыг хийсэн байна. Мөн байгууллагын дотоод хяналт шалгалтын хүрээнд төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлтийг хянаж, холбогдох албан хаагчдаар хувийн хэргийн бүрдлийг бүрэн бүрдүүлж, холбогдох мэдээ, судалгааг Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлд тухай бүр хүргүүлж, цаашид хийх ажлыг эрчимжүүлж, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлтэд анхаарч ажиллаж байна. | 100 |
| 2.2. | Төрийн байгууллага үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлах | Үйл ажиллагааны зардал | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд | Эрдэнэсант, Заамар, Баянчандмань | Зуунмод сумын БИНХ-ын товоор тухай бүрт, | Нийгмийн даатгалын газар нь иргэд даатгуулагчдын нийгмийн даатгалын ач холбогдлын талаарх ойлголт | 100 |

| | | | | | | | |
|--|--|--|---|--|---|---|--|
| | <p>“Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулан нийгмийн даатгалын ач холбогдлыг танин мэдүүлэх арга хэмжээ зохион байгуулан ажиллана</p> | | <p>хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар иргэд, даатгуулагчд ад хүрч үйлчлэн ач холбогдлыг танилцуулан хамрах хүрээг нэмэгдүүлэн ирээдүйн нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэн ажилласан байна.</p> | | <p>Батсүмбэр, Мөнгөнморьт, Эрдэнэ сум</p> | <p>мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах сургалт, нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулж байна. Тухайлбал, 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Монгол туургатан театрт 300 гаруй иргэд, даатгуулагчдад, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газартай хамтран 160 гаруй албан хаагчдыг хамарсан сургалтыг 05 дугаар сарын 15-ны өдөр, аймгийн Эрүүл мэндийн газрын 30 гаруй албан хаагчдад 05 дугаар сарын 27-ны өдөр тус тус зохион байгууллаа. Нийгмийн даатгалын багц хууль, нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Архуст, Мөнгөнморьт, Эрдэнэ суманд 2024 оны 05 дугаар сарын 13-18-ны өдөр, Алтанбулаг суманд 06 дугаар сарын 05-ны өдөр, Баяндэлгэр суманд 06 дугаар сарын 06-ны өдөр, Зуунмод сумын багийн иргэдийн нийтийн ээлжит 10 удаагийн хуралд, аж ахуйн нэгж байгууллагуудад захиалгат</p> | |
|--|--|--|---|--|---|---|--|

| | | | | | | | |
|--|--|--|--|--|--|---|--|
| | | | | | | сургалт мэдээлэл хийх зэрэг үйл ажиллагааг тус тус зохион байгууллаа. Түүнчлэн аймгийн “Төв телевиз”тэй хамтран ажиллах гэрээ байгуулж ТВ шууд нэвтрүүлэг, цахим мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээж, сурталчилж байна. Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга, үйлчилгээний талаар нийт 8 төрлийн гарын авлага боловсруулан хэвлэж сургалт, сурталчилгаанд ашиглаж байна. | |
|--|--|--|--|--|--|---|--|

ГУРАВ.ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Гүйцэтгэлийн зорилт3.Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагыг барагдуулах, Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах, Эмнэлэг хөдөлмөр магадлалын үйл ажиллагааг үзүүлэх

| | | | | | | | |
|-----|---|--------------------------|---|---|--|--|-----|
| 3.1 | Татварын байгууллагад бүртгэлтэй боловч нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллагыг нийгмийн даатгалд хамруулна. | Үйл ажиллагааны зардал | Шинээр хамрагдсан ажил олгогч даатгуулагчийн тоо | Шинээр 77 АО түүний 284 даатгуулагчийн хамруулсан | Хагас жилээр: 30 ажил олгогч, 120 даатгуулагч шинээр хамруулна | 2024 оны эхний хагас жилийн байдлаар 33 ажил олгогчийн 60 албан журмын даатгуулагчийг шинээр нийгмийн даатгалд хамруулсан байна. | 100 |
| 3.2 | Шимтгэлийн цахим системээр ажил олгогчийн тайланг 100% цахимаар хүлээн авч баталгаажуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Ажил олгогчоос цахимаар хүлээн авсан тайлангийн тоо | 896 ажил олгогч | 800 ажил олгогч | 2024 оны эхний хагас жилийн тайлант хугацаанд 870 ажил олгогчийн нийгмийн даатгалын тайланг цахимаар хүлээн авч баталгаажуулсан байна. | 100 |
| 3.3 | Даатгуулагч иргэний хөдөлмөрийн | ЭММЗ-ын зардал | Хөгжлийн бэрхшээлтэй | 2806 иргэн | Хөдөлмөрийн чадвар | Нийгмийн даатгалын багц хууль 2024.01.01-ний өдрөөс | 100 |

| | | | | | | | |
|--|---|--|--------------|--|--|--|--|
| | <p>чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөр зохицуулалт хийх арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.</p> | | иргэдийн тоо | | <p>алдалтын хувь, хугацаагаа хэлэлцэн шийдвэрлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоогоор</p> | <p>хэрэгжиж байгаатай холбогдуулан тус газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нэр хэлбэр Эрүүл мэндийн магадлалын зөвлөл болж өөрчлөгдөж, бүрэлдэхүүнийг НДЕГ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А/60 дугаар тушаалаар зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн байгуулагдсан. Тус газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 24 удаа 168 цаг хуралдаж 1495 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэлэлцсэн бөгөөд үүнээс 1278 хүний ХЧА-ын хугацааг сунгаж, 65 иргэний ХЧА-ыг шинээр тогтоосон, 36 иргэнийг цуцалсан, 115 иргэний ХЧА-ын хувь хугацааг өөрчлөн тогтоосон байна. 2024 оноос Засгийн газрын 448 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрмийг баримтлан иргэд, даатгуулагчдын ХЧА-ын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байгаа бөгөөд иргэдийг заавал биеэр</p> | |
|--|---|--|--------------|--|--|--|--|

| | | | | | | | |
|-----|---|--------------------------|---|---------------------|---|---|-----|
| | | | | | | ирүүлэхгүйгээр амбулаторийн үзлэгийн карт, холбогдох баримт бичигт үндэслэн хэлэлцэн шийдвэрлэж байна. | |
| 3.4 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулна. | ҮОМШӨ-ний сангийн зардал | Сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулсан байна. | 80 иргэн хамрагдсан | - | ААНБ, иргэд даатгуулагчдын нийгмийн даатгалын ач холбогдлын талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах сургалт, нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулж байна. Ялангуяа малчдын нийгмийн баталгааг хангах, тэднийг үйлдвэрлэлийн осолд өртсөн тохиолдолд нийгмийн баталгаагаа хэрхэн хангах талаарх сургалт сурталчилгааг эрчимжүүлж ажиллаж байна. Тухайлбал, Архуст, Мөнгөнморьт, Эрдэнэ, Алтанбулаг, Баяндэлгэр сумдад “Нээлттэй хаалганы өдөрлөг”, Зуунмод сумын багийн иргэдийн нийтийн ээлжит 10 удаагийн хурал арга хэмжээнд сургалт мэдээлэл хийх үйл ажиллагааг тус тус зохион байгуулав. Мөн Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх | 100 |

| | | | | | | | |
|--|--|--------------------------|---|--------------------------------|--|--|-----|
| | | | | | | дүрэм"-ийн 3.2-т заасан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс"-ыг байгуулах талаар сумдын засаг дарга нарт албан бичиг хүргүүлсний үр дүнд нийт сумдын 85 хувьд нь уг комисс шинээр байгуулагдаж, сайн дураар даатгуулагч, иргэдэд тохиолдож болзошгүй үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх, улмаар иргэд даатгуулагчдын нийгмийн баталгаа хангагдсан суурь нөхцөлийг бүрдүүлээд байна. | |
| 3.5 | Тэтгэврийн хувийн хэрэг дэх баримт бичгийг цахимжуулах ажлыг эхлүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Нийт хувийн хэргийг тоолж, тооллогын баримтаар хадгаламжийн нэгж үүсгэн, илэрсэн зөрчлийг арилгуулна. | Цахимжсан хувийн хэргийн тоо-0 | Нийт тэтгэврийн хувийн хэргийн 30 хувь буюу 5468-г цахимжуулна | Нийгмийн даатгалын салбарт 2024 оноос мэдээллийн системийн шинэчлэл хийгдэж байна. Аймгийн хэмжээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар шинээр тогтоогдсон 564 тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулаад байна. | 100 |
| ДӨРӨВ.ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |
| Гүйцэтгэлийн зорилт 4. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 10.4 дэх хэсэг 2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30 дугаар зүйл 30.1.3, 30.1.5, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай, Монгол хэлний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд | | | | | | | |
| 4.1 | Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яам, АИТХ- | Үйл ажиллагааны зардал | Хууль тогтоомж, ИТХ-ын | Хууль тогтоомж, шийдвэрүү | Хууль тогтоомж, шийдвэрүүди | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Аймгийн Засаг даргын үйл | 100 |

| | | | | | | | |
|-----|--|------------------------|--|---|---|--|-----|
| | ын, шийдвэр, аймгийн Засаг даргаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, тогтоол, шийдвэр, мөрийн хөтөлбөрийн биелэлтийг тайлагнана. | | тогтоол, АЗД-ын ҮАХ-ийн хэрэгжилт, ЗД-ын захирамж, даалгаврын биелэлтийн хувь. | дийн хэрэгжилт 90 дүгнэгдсэн. | йн хэрэгжилтийн 100% хэрэгжүүлэн ажилласан байна. | ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Төсвийн Ерөнхийлөн захирагч болон Төв аймгийн Засаг даргын хооронд байгуулсан хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилтийн гэрээний биелэлт, Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тус тус хугацаанд нь цаасан болон цахим хэлбэрээр тайлагнаж хүргүүлэв. | |
| 4.2 | Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Архивын зааврыг хэрэгжүүлэн ажиллаж, төрөлжсөн архивын хадгаламжийн нэгжийг баяжуулан ажилласан байна. | 48 албан хаагч архивын баримт хуулийн хугацаанд стандарт хангаж өгсөн | Хүлээн авсан хадгаламжийн нэгжийн тоогоор | Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу газрын болон сумдын байцаагч нар нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, сангийн харилцахын баримт, сайн дурын даатгалын гэрээ, зогсоогдсон тэтгэврийн хувийн хэрэг зэрэг баримт бичгийг хуульд заасны дагуу 2024 оны 1 дүгээр улиралд багтаан хүлээлгэн өгч, архивын нэгж үүсгэв. | 100 |
| 4.3 | Архивын баримтад тооллого явуулах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | Тооллого хийсэн байна | - | Архивын тооллого хийж дүнг гаргасан байна. | НДГазрын даргын 2023 оны А/03 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, газрын архивт хадгалагдаж байгаа санхүүгийн баримтыг нягтлан шалгах, эмхлэн | 100 |

| | | | | | | | |
|-----|---|------------------------|---|---------------------------------|------------------------------------|--|-----|
| | | | | | | цэгцлэх, хадгалах, устгах, хамгаалах ажлыг зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд устгах хэргийн жагсаалтыг гарган дээд шатны байгуулагад хүргүүлэв. | |
| 4.4 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хуулийн этгээдийн хүлээсэн нийтлэг үүргийг хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Сургалтын тоо, хамрагдсан албан хаагчийн тоо | 50 албан хаагч | 25 төрийн албан хаагчийг хамруулна | Нийгмийн даатгалын газрын хэмжээнд ХАСХОМ гаргах нийт 29 албан хаагчийн 18 нь ХАСХОМ-оо мэдүүлгээ хугацаанд нь гарган баталгаажуулав. | 100 |
| 4.5 | ЗДТГ-ын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг цаглабрын дагуу бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажилласан байна. | 90% | 100% | ЗДТГ-ын нэгдсэн төлөвлөгөөний тус газарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан. Тухайлбал, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулах, бууруулах, орлогын төлөвлөгөөг биелүүлэх төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. | 100 |
| 4.6 | ЗГХЭГ-ын харьяа Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалт /танхимын болон зайн, урт болон богино хугацааны/- д болзол шаардлага хангасан төрийн | Үйл ажиллагааны зардал | Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | 2 төрийн захиргааны албан хаагч | 1 төрийн захиргааны албан хаагч | Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 онд дунд хугацааны хөтөлбөрт 1 албан хаагч, богино хугацааны хөтөлбөрт 3 албан хаагч хамрагдав. Мөн 2024 оны дунд хугацааны сургалтын хөтөлбөрт 2 албан хаагч хамрагдаж байна. | 100 |

| | | | | | | | |
|-----|--|------------------------|--|-------------------------------|---|--|-----|
| | албан хаагчдыг хамруулах саналыг холбогдох газарт хүргүүлнэ. | | | | | | |
| 4.7 | Хууль тогтоомжийн болзол, шаардлага хангасан төрийн жинхэнэ албан хаагчдад зэрэг дэв олгуулах саналыг холбогдох газарт шийдвэрлүүлэхээр хугацаанд нь хүргүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Зэрэг дэв олгосон ТЖАХ-ийн тоо | 9 байцаагч | Шинээр олгосон, ахиулсан төрийн захиргааны албан хаагчийн тоогоор | Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасны дагуу зэрэг зэвийн нэмэгдэл олгохоор аймгийн Засаг даргын 2024 оны Б/03 дугаар захирамжийн дагуу 5 байцаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг тооцож олгов. | 100 |
| 4.8 | Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг шинэ албан хаагчийн “Чиглүүлэх болон дасан зохицох хөтөлбөр”-т хамруулж ажлын байранд нь мэргэшүүлэн ажиллуулах арга хэмжээг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | Албан хаагчийн тоо | 8 шинэ албан хаагч хамрагдсан | Хөтөлбөрт хамрагдсан шинэ төрийн албан хаагчийн тоогоор | ТАЗ-өөс зохион байгуулж байгаа “Асуудал, шийдэл” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд Сургалт, сурталчилгаа, мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Төрбат, Тэтгэмжийн байцаагч С.Ариунтөгс, Тэтгэврийн байцаагч Б.Доржготов нар оролцов. | 100 |
| 4.9 | Нийгмийн даатгалын ач холбогдол, 2024 оноос шинээр хэрэгжиж буй нийгмийн даатгалын багц хуулийг хэвлэл | Үйл ажиллагааны зардал | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо, | 17610 даатгуулагч | 9000 даатгуулагч | Нийгмийн даатгалын хууль тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлт, шинээр хэрэгжиж буй хууль тогтоомж болон цахим нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах | 100 |

| | | | | | | | |
|------|---|-------------------------------|--|---|--|---|-----|
| | <p>мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчлан таниулах, иргэд даатгуулагчдын ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.</p> | | <p>зар мэдээлэл, сурталчилганы тоо</p> | | | <p>сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тайлант хугацаанд 16 удаагийн сургалтаар 8000 гаруй иргэд, даатгуулагчдыг хамруулан ажиллалаа. Газрын фэйсбүүк хуудсаар дамжуулан нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 58 удаагийн зар, мэдээллийг тухай бүрт иргэд даатгуулагчдад хүргэж, tuv.ndaatgal.mn газрын цахим хуудсанд Засгийн газрын 143 дугаар тогтоолоор баталсан “Мэдээллийн ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу мэдээллийг шинэчилж, баяжилтыг хийн ажиллаж байна.</p> | |
| 4.10 | <p>Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, дээд шатны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг хамруулна.</p> | <p>Үйл ажиллагааны зардал</p> | <p>Зохион байгуулсан сургалтын тоо, давхардсан тоогоор байцаагчийн тоо</p> | <p>10 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 450 байцаагчийг хамруулсан</p> | <p>Давхардсан тоогоор 250 байцаагчийг сургалтад хамруулан ажиллана</p> | <p>Сумдын нийгмийн даатгалын байцаагч нарт 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр цахим сургалт зохион байгуулав. Энэхүү сургалтаар сумдын албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийг хэрхэн хэрэгжүүлэх талаар сургалт мэдээлэл хийсэн. Мөн Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг</p> | 100 |

| | | | | | | | |
|------|--|------------------------|--|------|-----|--|-----|
| | | | | | | хэрэгжүүлэх чиглэлээр газрын болон сумдын байцаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, чиглэл зөвлөмж өгөх сургалтыг 10 удаа цахим хэлбэрээр зохион байгуулсан. | |
| 4.11 | Жендерийн дэд салбар зөвлөл байгуулж, 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Төлөвлөгөөний хэрэгжилт | 100% | 50% | Газрын даргын 2023 оны А/06 дугаар тушаалаар Жендерийн эрх тэгш байдлыг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |
| 4.12 | Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын 1-р шатыг хэрэгжүүлж, төсөвлөлт, бичил төслийг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлэх, үр дүнг аймгийн салбар хороонд хагас, бүтэн жилээр тайлагнана. | Үйл ажиллагааны зардал | Оюунлаг эмэгтэйчүүд, Илүүдэл жингүй-эмэгтэйчүүд төслүүд бүрэн хэрэгжсэн байна. | - | 50% | Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын 1-р шатыг хэрэгжүүлж, төсөвлөлт, бичил төслийг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор газрын албан хаагчдын дунд Оюунлаг эмэгтэйчүүд, Илүүдэл жингүй-эмэгтэйчүүд төслүүдийг хэрэгжүүлж байна. | 100 |
| 4.13 | Цахим модуль сургалтад байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулж, судалгааг сүүлийн 3 жилээр гаргана. | Үйл ажиллагааны зардал | Шинээр томилогдсон болон хамрагдаагүй албан хаагчдыг бүрэн хамруулна. | 1 | 5 | “Жендэрт суурилсан хүчирхийлэл” сэдэвт сургалтад газрын 3 албан хаагчийг цахимаар хамруулсан. Мөн 1 албан хаагчийг ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ | 100 |

| | | | | | | | | |
|------|---|------------------------|-----------------------------|---|--|--|-----------|-----|
| | | | | | | цахим хамруулсан. | сургалтад | |
| 4.14 | Нийгмийн даатгалын үйлчилгээ авагчдын тоо мэдээлэлд үндэслэсэн жөндөрт суурилсан статистик мэдээллийн санг баяжуулна. | Үйл ажиллагааны зардал | Цаасан болон цахим мэдээлэл | Үйлчилгээ авсан иргэд, даатгуулагчдын судалгааг жөндөрт суурилан гаргах | Жөндөрт суурилсан судалгаа мэдээллийн санг баяжуулсан байна. | Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, тэтгэвэр, тэтгэмж авагчдын хүйсээр ангилсан мэдээллийн сантай болсон. | | 100 |

ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР